

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
	2.1. Оршил.....	5
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
	2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
	2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
	2.9 Зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
	2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
	2.12. Шилэн дансны мэдээлэл	9
	2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
	2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
	4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
	4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
	4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
	4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
	4.5 Зорилтот түвшин, гүйцэтгэл.....	17
5	Аудит явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ЗТ, ЭЗҮҮ	Зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХОВД ДУЛААНЫ СТАНЦ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.ЭНХСАЙХАН ТАНАА

2020. 03. 13 № 06/827
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ховд дулааны станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийв.

Зөрчилгүй дүгнэлт

Ховд дулааны станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ховд дулааны станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Ховд дулааны станц ТӨХК-ийн удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн 8 дугаар зүйл болон СТОУС, НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Ховд дулааны станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал Д.Энхсайхан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, байгууллагын худалдан авалтын үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмын хэрэгжилтийг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ховд дулааны станц ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Ховд дулааны станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Ховд дулааны станц ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль, стандарт болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Ховд дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захиралд хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн аудитор Н.Дэлгэрмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Ховд дулааны станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 54 тоот албан бичгээр Ди Эй Би Жи Аудит ХХК-д аудит хийлгэх хүсэлтийн хамт ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Ховд дулааны станц ТӨХК нь ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлэгч баруун бүсийн загвар байгууллага болох эрхэм зорилгын дор нэгдэж, хэрэглэгчдийг стандартад нийцсэн дулааны эрчим хүчээр хангах уриатайгаар 2019-2020 оны халаалтын улиралд 1600 айл өрх, 24 төсөвт байгууллага, 73 аж ахуйн нэгж байгууллагын 701.4 мянган метр куб эзлэхүүнтэй хэрэглэгчдийг эрчим хүчээр ханган ажиллахаар байна.

Үйл ажиллагааны чиглэл:

- Дулаан үйлдвэрлэх
- Дулаан түгээх
- Дулаан зохицуулалттай хангах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 243 тогтоолоор Ховд дулааны станц ТӨХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг шинэчлэн баталсан
- Гүйцэтгэх захирлын 2019 оны А/56 тушаалаар Өмч хамгаалах байнгын зөвлөлийг 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Ховд дулааны станц ТӨХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжид бүрэн нийцээгүй, сайжруулах шаардлагатай байна.

Ховд дулааны станц ТӨХК-ийн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Юникус программ хангамж ашигладаг байна.

Ховд дулааны станц ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Ховд дулааны станц ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад, дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 8 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн

санхүүгийн тайлангаарх нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 12,818.5 сая төгрөгөөс тооцон 128.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 126.4 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн сонгосон суурь үзүүлэлтээс тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Ховд дулааны станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 547.1 сая төгрөгөөр буюу 4.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /сая төгрөг/
Мөнгөн хөрөнгө	11.1	4.7	(6.40)
Авлага	254.2	240.3	(13.9)
Урьдчилж төлсөн зардал	16.0	0.6	(15.4)
Бараа материал	656.6	705.3	48.7
Үндсэн хөрөнгө	12,036.0	11,479.9	(556.1)
Биет бус хөрөнгө	218.0	214.0	(4.0)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,191.9	12,644.8	(547.1)
Богино хугацаат өр төлбөр	326.3	815.2	488.9
Урт хугацаат өр төлбөр	532.9	343.9	(189.0)
Төрийн өмч	13,285.9	13,285.9	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	(111.9)	1,157.0	1,268.9
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	202.1	202.1	-
Хуримтлагдсан үр дүн	(1,043.4)	(3,159.3)	(2,115.9)
НИЙТ ӨР ТӨЛБӨР, ӨМЧИЙН ДҮН	13,191.9	12,644.8	(547.1)

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан нь байгууллагын үйл ажиллагаанд зарцуулах санхүүжилтийн эх үүсвэр дутмаг байгаа нь шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл буурсан үзүүлэлттэй байгаа боловч айл өрхүүд болон аж ахуйн нэгж байгууллагын авлагын дүнд нэг жилээс дээш насжилттай, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 84.2 сая төгрөгийн төлбөр тооцооны үлдэгдэл байна. Үүнээс 2 байгууллагын 56.3 сая төгрөгийн авлагыг шүүхэд нэхэмжлэл гаргасан хэлэлцэх шатандаа байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 555.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардал 727.5 сая төгрөгөөр буурч, худалдан авалтын төлөвлөгөөний дагуу 171.4 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг Эрчим хүчний зохицуулах хорооны 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 53 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу тооцоолдог байна.

Богино хугацаат өр төлбөрийн данс 488.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төлбөр тооцоо гүйцэтгэх санхүүгийн эх үүсвэр дутагдалтай байдлаас шалтгаалжээ. Санхүүгийн эх үүсвэр дутагдалтай байгаа талаар Эрчим хүчний зохицуулах хорооны дүгнэлтийг үндэслэн улсын төсвөөс татаас авахаар холбогдох байгууллагуудад хүсэлт гаргасан боловч Сангийн яамнаас

зөвшөөрөөгүй байна. 2019 оны худалдан авалтын үйл ажиллагааны үр дүнд Мон Энко ХХК-д нүүрсний өглөг 226.4 сая төгрөг, Төгс соёмбо транс ХХК-д 99.5 сая төгрөг, Мөнх таван эрдэнэ БГБХН-т 130.4 сая төгрөгийн нүүрс тээвэрлэлтийн өглөг, Хасу-Эрчим ХХК-д их засварын ажлын хөлс 99.3 сая төгрөг, МЭЗ ХХК-д сэлбэг хэрэгсэл худалдан авсны тооцоо 20.9 сая төгрөг, Си Би Ай Аутсорс ХХК-д 14.6 сая төгрөг, Ховд ЦТС ХХК-д цахилгаан эрчим хүчний тооцоо 167.8 сая төгрөгийн өглөг үүссэн байна.

Урт хугацаат өр төлбөр 188.9 сая төгрөгөөр буурсан нь Хас банкны урт хугацаат зээлийн төлбөр төлсөнөөс шалтгаалсан байна. Хас банкнаас 2018 онд 590.0 сая төгрөгийн урт хугацаат зээл авч тухайн оны батлагдсан төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалтын ажил, сэлбэг бараа материалын худалдан авалтыг санхүүжүүлсэн байна. Зээлийн төлбөрт сар бүр 20.0 сая төгрөг төлөхөөр хуваарьтай ч борлуулалтын орлого бүрдээгүйгээс 5-9 дүгээр саруудад төлөх эх үүсвэр дутмаг байснаас 4.1 сая төгрөгийн зээлийн хүүгийн алдагдал хүлээсэн байна.

2.9 Зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Эрчим хүчний сайдын 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 13 тоот тушаал, Ховд дулааны станц ТӨХК-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн 01 тоот тогтоолоор 2019 оны зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталсан байна. Тайлант онд 2,110.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 3,567.3 сая төгрөгийг зарцуулж, 1,456.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, улсын төсвөөс 1,400.0 сая төгрөгийн татаас авч зарцуулахаар төлөвлөсөн байна.

Тайлант онд 2,110.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 2,374.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 113.5 хувиар биелүүлсэн байна.

Орлого 264.2 сая төгрөгөөр давсан нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 243 тогтоолоор Ховд дулааны станц ТӨХК-ийн эзэмшлийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг шинэчлэн тогтоосноос шалтгаалсан байна.

Тайлант оны үйл ажиллагаанд 3,567.3 сая төгрөгийг зарцуулахаар баталсан нь өмнөх оны зардлын гүйцэтгэлээс 515.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь ажилтнуудын цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, түлш, шатахуун, цахилгаан, сэлбэг хэрэгсэл, урсгал засварын зардлуудыг нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна.

Батлагдсан зорилтот түвшин, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн төлөвлөгөөний гүйцэтгэл 3,242.2 сая төгрөг буюу 90.0 хувьтай байна.

Зардлуудаас материаллаг дүнтэй дутуу зарцуулалтын шалтгааныг авч үзэхэд:

- Цалинтай холбоотой зардал 130.5 сая төгрөг дутуу зарцуулсан нь 5-9 дүгээр саруудад үйлдвэрлэл зогссон үед цалин олгоогүй, ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлийг сул зогсолтын үнэлгээгээр бодсон;
- Ашиглалтын зардал 100.1 сая төгрөг дутуу зарцуулсан нь 5-9 дүгээр саруудад үйлдвэр зогссонтой холбоотой ус, цахилгаан, нүүрсний зардлууд зарцуулагдаагүй;
- Хөдөлмөр хамгааллын зардал 43.4 сая төгрөг дутуу зарцуулсан нь санхүүжилтийн эх үүсвэр дутуугаас худалдан авалтын төлөвлөгөөнд тусгасан зарим багаж хэрэгсэл, хувцсыг худалдан аваагүй, худалдан авсан ажлын гутлыг өмнөх олгосон нормын хугацаа болоогүй учир тавьж олгоогүй;
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 69.1 сая төгрөг дутуу байгуулсан нь худалдан авахаар төлөвлөсөн хөрөнгийг дутуу бэлтгэсэн;
- Удирдлагын зардал 30.9 сая төгрөг дутуу зарцуулсан нь зарим албан томилолт, сургалтыг цуцалсан;

- Бусад зардал 59.7 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь санхүүгийн эх үүсвэр дутуугаас ашиглалт үйлчилгээний төлбөр, лаборатори шинжилгээний дүгнэлт, байгаль орчин хамгаалах зардлуудыг хэмнэж, гишүүн байгууллагын хураамжийг дутуу төлсөн байна.

Тайлант онд 1456.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, алдагдлыг улсын төсвөөс 1,400.0 сая төгрөгийн татаас олгохоор төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 846.6 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж 610.3 сая төгрөгөөр алдагдлыг бууруулсан байна.

2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 8 эрсдэл тодорхойлж, нийт 23 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,355.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,268.8 сая төгрөгийн алдааг залруулж, 86.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 2 алдааг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

- Өмнөх онд хийгдсэн дахин үнэлгээний тайланд 1,268.8 сая төгрөгийн үнэлгээний бууралтыг зардалд бүртгээгүй, нэмэгдлийг бууруулан тайлагнасан нь НББОУС-16.40-д “хэрэв дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурвал тэрхүү бууралтыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө” гэсэн заалттай нийцэхгүй, үнэлгээ, иж бүрэн, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэлийн тайланг санхүүгийн тайланд хавсаргаагүй, тайлагнаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 69.2-д “Заавал хөтлөх нягтлан бодох бүртгэлийн нийтлэг маягтаас гадна төрийн өмчийн хуулийн этгээдэд хөтлөгдвөл зохих мэдээ, тайлангийн маягт, аргачлалыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батлан мөрдүүлж болно.” гэсэнтэй нийцэхгүй, эрх ба үүрэг, тайлагнал тодруулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Залруулагдаагүй 86.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмжийг менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Ховд дулааны станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэхээр хуваарилагдсан цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан бараа материал, үндсэн хөрөнгийн биет үлдэгдэлд нарийвчилсан горим сорил гүйцэтгээгүй болно.

Дараагийн аудитаар хөрөнгийн үлдэгдэлд хяналтын тооллого хийж чанар байдал, нөөцийн үлдэгдэл зохистой хэмжээнд байгаа эсэхийг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Ховд дулааны станц ТӨХК-ийн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 160 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2 алдаа зөрчил илрүүлж, үүнээс 2 асуудлаар зөвлөмж өгснөөс 100 хувь буюу бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Ховд дулааны станц ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт:

Аудитаар залруулагдаагүй 86.9 сая төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон 126.4 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Ховд дулааны станц ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Худалдан авалтын үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: 2019 оны худалдан авалтын төлөвлөгөөнд батлагдаагүй 36.9 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 22.1 сая төгрөгийн хүнсний бараа материалыг тендер зарлаагүй, харьцуулалт хийгээгүй жижиг дүнгээр олон хувааж шууд худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

3.1.2 Эрсдэл: Худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг үр өгөөжтэй, хэмнэлттэй байхаар төлөвлөн гүйцэтгэх. Цаашид алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, худалдан авалтын ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэснийг мөрдөж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3.2 Балансын данстай холбоотой асуудал

- 3.2.1 Илрүүлэлт 2019 оны жилийн эцсийн тайланд нэг жилээс дээш насжилттай айл өрхүүдийн борлуулалтын авлага 22.5 сая төгрөг, 4 байгууллагын 5.4 сая төгрөг, нийт 27.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэснийг хэрэгжүүлээгүй байна.
- 3.2.2 Эрсдэл Найдваргүй авлага үүсэх
- 3.2.3 Өгсөн зөвлөмж Тайлант хугацааны эцэст авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан тайлагнах, насжилтаар нь ангилан хянаж, эрсдэл үүсэхээр бол хууль хяналтын байгууллагад цаг алдалгүй шилжүүлэн шийдвэрлүүлэх, цаашид алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх.
- 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан**4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
	ХӨРӨНГӨ		
	Эргэлтийн хөрөнгө		
1.1.01	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	11,121,196.58	4,717,187.10
1.1.02	Дансны авлага	216,124,028.38	240,271,363.44
1.1.03	Татвар, шимтгэлийн авлага	38,105,622.68	-
1.1.04	Бусад авлага	-	597,083.31
1.1.06	Бараа материал	656,580,523.73	705,354,780.43
1.1.07	Урьдчилж төлсөн зардал тооцоо	16,036,300.00	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	937,967,671.37	950,940,414.28
	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.01	Үндсэн хөрөнгө	12,036,049,771.75	11,479,936,323.49
1.2.02	Биет бус хөрөнгө	217,981,222.20	214,017,999.92
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	12,254,030,993.95	11,693,954,323.41
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,191,998,665.32	12,644,894,737.69
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
	ӨР ТӨЛБӨР		
	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.01	Дансны өглөг	317,867,841.00	799,502,275.15
2.1.1.03	Татварын өр	2,006,979.42	9,965,622.57
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	6,473,333.00	5,775,541.50
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	326,348,153.42	815,243,439.22
	Урт хугацаат зээл		
2.1.2.01	Урт хугацаат зээл	532,903,225.82	343,940,092.22
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	532,903,225.82	343,940,092.22
2.2	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	859,251,379.24	1,159,183,531.44
	Эздийн өмч		
2.3.01	Төрийн өмч	13,285,935,498.23	13,285,935,498.23
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	(111,888,595.92)	1,156,971,401.82
2.3.08	Эзпийн өмчийн бусад хэсэг	202,150,000.00	202,150,000.00
2.3.09	Хуримтлагдсан үр дүн	(1,043,449,616.23)	(3,159,345,693.80)
2.3.09.1	Өмнөх үеийн үр дүн	(1,043,449,616.23)	(2,312,309,613.97)
2.3.09.2	Тайлангийн үеийн үр дүн	-	(847,036,079.83)
2.3.11	Эздийн өмчийн дүн	12,332,747,286.08	11,485,711,206.25
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	13,191,998,665.32	12,644,894,737.69

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
01	Борлуулалтын орлого	2,084,581,212.36	2,374,601,671.34
02	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,505,183,608.01	2,737,860,195.40
03	Нийт ашиг (алдагдал)	(420,602,395.65)	(363,258,524.06)
05	Хүүний орлого	3,240,499.00	898,046.42
08	Бусад орлого	122,097,460.25	20,097,680.96
08.1	Үндсэн үйл ажиллагааны орлогын дүн	125,337,959.25	20,995,727.38
09	Борлуулалт, маркетингийн зардал	99,047,586.59	106,240,712.46
10	Ерөнхий ба удирдлагын зардал	447,350,866.89	398,118,716.15
12.1	Үйл ажиллагааны зардлын дүн	546,398,453.48	504,359,428.61
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(841,662,889.88)	(846,622,225.29)
19	Орлогын татварын зардал	-	413,854.54
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(841,662,889.88)	(847,036,079.83)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(841,662,889.88)	(847,036,079.83)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,482,309,287.97	2,580,922,711.42
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэн орлого	2,369,876,739.97	2,529,085,551.00
1.1.3	Даатгалын нөхөн олговор	6,637,452.00	1,976,910.00
1.1.6	Бусад орлого	105,795,096.00	49,860,250.42
1.2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	2,779,262,005.77	2,335,235,587.30
1.2.1	Ажилчдад төлсөн мөнгө	749,910,403.29	764,317,380.85
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	227,149,189.00	249,824,223.55
1.2.3	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	454,462,320.00	313,323,849.16
1.2.4	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	496,702,399.00	373,616,247.00
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	525,515,825.46	368,391,214.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн мөнгө	28,532,744.14	81,818,437.05
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	287,502,122.98	174,679,144.89
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,178,250.00	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	8,308,751.90	9,265,090.80
1.3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(III)=(I)-(II)	(296,952,717.80)	245,687,124.12
2.2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (V)		
2.2.1	Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө	237,376,027.00	63,128,000.00
2.2.6	Бусад	144,000.00	-
2.3	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(237,520,027.00)	(63,128,000.00)
3.1	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)		
3.1.1	Банкнаас авсан зээл	590,000,000.00	-
3.2.1	Зээлийн төлбөр	57,096,774.18	188,963,133.60
3.3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	532,903,225.82	(188,963,133.60)
4	БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,569,518.98)	(6,404,009.48)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,690,715.56	11,121,196.58

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	13,285,935,498.23	-	-	(190,386,726.35)	13,095,548,771.88
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				(11,400,000.00)	(11,400,000.00)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,285,935,498.23	-	-	(201,786,726.35)	13,084,148,771.88
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт	-	(111,888,595.92)	-		(111,888,595.92)
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	202,150,000.00	-	202,150,000.00
6	Тайлант үеийн үр дүн	-		-	(841,662,889.88)	(841,662,889.88)
7	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	13,285,935,498.23	(111,888,595.92)	202,150,000.00	(1,043,449,616.23)	12,332,747,286.08
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		1,268,859,997.74		(1,268,859,997.14)	-
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,285,935,498.23	1,156,971,401.82	202,150,000.00	(2,312,309,613.37)	12,332,747,286.08
10	Тайлант үеийн үр дүн				(847,036,079.83)	(847,036,079.83)
11	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	13,285,935,498.23	1,156,971,401.82	202,150,000.00	(3,159,345,693.20)	11,485,711,206.25

4.5 Зорилтот түвшин, гүйцэтгэл

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/Сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого	2,110.4	2,395.6	285.2	113.5
Үүнээс: Цэвэр борлуулалт	2,110.4	2,374.6	264.2	112.5
Нийт зардал	3,567.3	3,242.2	(325.1)	90.9
Үүнээс: Удирдлагын зардал	364.8	398.1	33.3	109.1
Борлуулалт маркетингийн зардал	49.2	106.2	57.0	215.9
Татварын өмнөх ашиг /алдагдал/	(1,456.9)	(846.6)	610.3	58.1
Орлогын татварын зардал	-	0.4	0.4	
Цэвэр ашиг /алдагдал/	(1,456.9)	(847.0)	609.9	58.1
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	1.7	1.4	(0.3)	80.1
Нийт авлага	191.0	240.3	49.3	125.8
Нийт өр төлбөр	424.0	1,159.2	735.2	273.4
Үүнээс: Богино хугацаат өр төлбөр	120.0	815.2	695.2	679.3
Урт хугацаат өр төлбөр	304.5	343.9	39.4	112.9
Хөрөнгө оруулалт, их засвар	334.5	197.4	(137.1)	59.0
Ажиллагсадын тоо	108.0	107.0	(1.0)	99.1
Цалингийн сан	976.8	853.3	(123.5)	87.4

5 Аудит явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.03.13	Аудитын н нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2020/73/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Ховд дулааны станц ТӨХК			Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	З	4	5	8	9
1	2019 оны худалдан авалтын төлөвлөгөөнд батлагдаагүй 36.9 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 22.1 сая төгрөгийн хүнсний бараа материалыг тендер зарлаагүй, харьцуулалт хийгээгүй жижиг дүнгээр олон хувааж шууд худалдан авалт хийсэн	59.0	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан	Д.Энхсайхан Ц.Энхмөрөн
2	2019 оны жилийн эцсийн тайланд нэг жилээс дээш насжилттай айл өрхүүдийн борлуулалтын авлага 22.5 мянган төгрөг, 4 байгууллагын 5.4 мянган төгрөг, нийт 27.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан	27.9	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан	Д.Энхсайхан Ц.Энхмөрөн
Нийт дүн		86.9			

